



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2024 оны 07 сарын 01 өдөр

Дугаар А/296

Улаанбаатар хот

Магадлан итгэмжлэл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэг, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/503 дугаар тушаалын 3.1 дэх хэсэг, Магадлан итгэмжлэх зөвлөлийн 2024 оны 8 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын нэрсийг хавсралтаар баталж, батламжийг олгосугай.

2. Магадлан итгэмжлэлийн хугацаанд тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах ажлыг тасралтгүй зохион байгуулж, шинжээчдийн багийн өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх зөвлөлийн 2024 оны 7 дүгээр сарын 01-ний өдрийн наймдугаар хурлын шийдвэрийг холбогдох эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар (С.Эрдэнэтуяа)-т, Эрүүл мэндийн хөгжлийн төв (Б.Нарантуяа)-д тус тус даалгасугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбарын хяналтын газар (Л.Гэрэлмаа)-т даалгасугай.

САЙД



С.ЧИНЗОРИГ

141241341

Эрүүл мэндийн сайдын 2024 оны  
07 сарын 01 - ны өдрийн 429  
дугаар тушаалын хавсралт

МАГАДЛАН ИТГЭМЖЛЭГДСЭН ЭРҮҮЛ МЭНДИЙН  
БАЙГУУЛЛАГЫН НЭРС

№	Эрүүл мэндийн байгууллагын нэрс	Батламжийн дугаар	Магадлан итгэмжлэгдсэн хугацаа	Магадлан итгэмжлэл эхлэх огноо	Магадлан итгэмжлэл дуусах огноо
1.	Нийслэлийн Сүхбаатар дүүрэг, Сайн наран өрхийн эрүүл мэндийн төв	181/2024	2 жил	2024.07.21	2026.07.21
2.	Бумаа санаа ББН-ийн эмнэлэг	182/2024	3 жил	2024.07.27	2027.07.27
3.	Дорнод аймаг, Асралт үйлс өрхийн эрүүл мэндийн төв	183/2024	3 жил	2024.07.04	2027.07.04
4.	Дорнод аймаг, Ягаанцээнэ өрхийн эрүүл мэндийн төв	184/2024	3 жил	2024.07.01	2027.07.01
5.	Дорнод аймаг, Дашбалбар сумын эрүүл мэндийн төв	185/2024	2 жил	2024.07.04	2026.07.04
6.	Дорнод аймаг, Матад сумын эрүүл мэндийн төв	186/2024	2 жил	2024.07.01	2026.07.01
7.	Дорнод аймаг, Цотан сувд ХХК-ийн "Этүгэн эх" эмнэлэг	187/2024	2 жил	2024.07.04	2026.07.04
8.	Өмнөговь аймаг, Булган сумын эрүүл мэндийн төв	188/2024	2 жил	2024.07.08	2026.07.08
9.	Өмнөговь аймаг, Гурвантэс сумын эрүүл мэндийн төв	189/2024	2 жил	2024.07.08	2026.07.08
10.	Хэнтий аймаг, Тахилгат тосгоны эрүүл мэндийн төв	190/2024	2 жил	2024.07.25	2026.07.25
11.	Хэнтий аймаг, Хэрлэнбаян-Улаан тосгоны эрүүл мэндийн төв	191/2024	2 жил	2024.08.13	2026.08.13
12.	Хэнтий аймаг, Баянмөнх сумын эрүүл мэндийн төв	192/2024	2 жил	2024.09.07	2026.09.07
13.	Хэнтий аймаг, Цэнхэрмандал сумын эрүүл мэндийн төв	193/2024	2 жил	2024.08.13	2026.08.13
14.	Хэнтий аймаг, Баянхутаг сумын эрүүл мэндийн төв	194/2024	2 жил	2024.08.13	2026.08.13
15.	Хэнтий аймаг, Хилийн цэргийн 0287-р ангийн эрүүл мэндийн төв	195/2024	2 жил	2024.07.21	2026.07.21
16.	Баян-Өлгий аймаг, Цэнгэл сумын эрүүл мэндийн төв	196/2024	2 жил	2024.07.08	2026.07.08
17.	Баян-Өлгий аймаг, Улаанхус эрүүл мэндийн төв	197/2024	2 жил	2024.07.08	2026.07.08
18.	Баян-Өлгий аймаг, "АХСУ" ХХК-ийн "АХСУ" рашаан сувилал	198/2024	1 жил	2024.07.08	2025.07.08